



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/251

Улаанбаатар хот

**Хаягдал ус хаях, зайлуулах  
зөвшөөрөл олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.3 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2.1.14 дэх заалт, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны 2023 оны 73, 74, 86 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Усны нөөцийг ашиглан хаягдал ус гаргаж, усны найрлага, чанарт нөлөөлж байгаа ус бохирдуулагч хавсралтад заасан аж ахуйн нэгж, байгууллагад хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгосугай.

2. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасаг (Э.Юмжирмаа)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2023 оны ..... дугаар сарын ..... ны өдрийн  
А/23/ дугаар захирамжийн хавсралт



ХАЯГДАЛ УС ХАЯХ, ЗАЙЛУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ  
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Байршил	Хаягдал усны дүгнэлтийн дугаар	Жилд хаях усны хэмжээ (м.куб)	Зөвшөөрөл олгох хугацаа
1	"Синвоюань" ХХК	1-р хороо, Үйлдвэрийн бүс-Задгай	2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 73 дугаар дүгнэлт	1890.0м.куб	1 жил
2	"Хангайнган Эрдэнэ" ХХК	1-р хороо, Үйлдвэрийн бүс-Задгай	2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 74 дүгээр дүгнэлт	2970.0м.куб	1 жил
3	"Трансгайд сервис" ХХК	2 дугаар хороо, Замчид, 09-12 тоот	2023 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн 86 дугаар дүгнэлт	1296.0м.куб	1 жил